



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар Д/163

Хэрлэн сум


**Постод хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Баянхутаг сумын 1 дүгээр багийн нутагт 14 хоногийн хугацаатай түр хяналтын пост гаргаж Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт уруудан очсон малыг татан авах, хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулахад 3,360,000 (гурван сая гурван зуун жаран мянган) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн цасан болон шороон шуурга, ган зуд байгалийн гамшиг тохиолдсон үед түүний хохирлыг бууруулах, үр дагаврыг арилгах зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ